

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04 дүгээр сарын
30-ны өдөр

№ ХЭХ 03/01

Улаанбаатар
хот

**“Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тэмдэглэл.**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 сарын 30-ны өдөр 16:00 минут, Пүрэв гараг, Хан Уул дүүргийн 15-р хороо, Махатма Ганди гудамж, Барилгын төслийн талбайд байрлах оффисын 1-р давхрын хурлын танхимд хуралдав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сайн байцгаана уу. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг ХЭХ-ийн материалд оруулсан байгаа. Энэ дэгийн дагуу өнөөдрийн хурал зохион байгуулагдана. Хурлыг дэгийг дэлгэрэнгүй байдлаар хурлын дарга хурлыг нээж үг хэлсний дараа танилцуулна.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаяр: Сайн байцгаана уу та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Жил бүр 4 дүгээр сард зохион байгуулагддаг хуралдаа хүрэлцэн ирж оролцож байгаа хувьцаа эзэмшигч нартаа талархал илэрхийлье. Хурлын хүрээнд нийт 7 асуудлыг хэлэлцэхээр байна. Тооллогын комиссын даргын танилцуулснаар хурлын ирц бүрдсэн тул хурлыг эхлүүлье.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлын ирц бүртгэлийн талаар тооллогын комиссын дарга Э.Оюунпүрэв танилцуулна.

Тооллогын комиссын дарга Г.Намуунаа: Сайн байцгаана уу. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит энэ хуралд 3 хувьцаа эзэмшигч биеэр оролцож, нийт саналын эрх бүхий нийт хувьцааны 77 хувь болж байгааг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар болон хурлын даргад мэдээлсүгэй. Ингэснээр хурлыг хүчин төгөлдөрт тооцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг үргэлжлүүлэхэд ирц хүрсэн байна.

Тооллогын комиссоос гарч буй Хурлын ирцийн тогтоолыг танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр болсон байна. Тооллогын комиссоос тогтоол гарсантай та бүхэн танилцлаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийг танилцуулъя. Ц.Отгонбаяр захиралд баярлалаа. Хурлыг нээж үг хэллээ. Ингээд хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2026 оны 04 сарын 30-ны өдрийн хурлын даргаар Ц.Отгонбаяр захирал ажиллаж байгаа. Хурлаар хэлэлцэх асуудал.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах /Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаяр/
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/

3. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах /Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга/
4. Компанийн 2025 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/
5. Компанийн 2026 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах /Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга/
6. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, батлах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/
7. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр томилох, батлах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/

гэх 7 асуудлыг энэхүү хурлаар хэлэлцэнэ. Та бүхэнд хүргүүлсэн хурлын материалд дээрх 7 асуудлыг тодорхой тусгасан байгаа.

№	Үйл ажиллагаа	Хариуцагч	Хугацаа
1	Хурлын ирц бүртгэх, ирц мэдээлэх, тооллогын комиссын тогтоол танилцуулах	Тооллогын комисс Э.Оюунпүрэв	15:50-16:10
2	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулах.	Хурлын дарга: Ц.Отгонбаяр	16:15-16:20
3	Хурлаар хэлэлцэх асуудал 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах; 2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах; 3. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах; 4. Компанийн 2025 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; 5. Компанийн 2026 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах 6. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, батлах; 7. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох, батлах;	1. Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаяр 2. Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга 3. Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга 4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ 5. Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга 6. Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаяр 7. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ	16:20- 16:30 16:30-16:35 16:35-16:40 16:40-16:50 16:50-17:00 17:00-17:05 17:05-17:10
4	Асуулт, хариулт	Хурлын дарга, хуралд оролцогчид	17:10-17:20
5	Хэлэлцсэн асуудлаар санал хураалт	Тооллогын комисс	17:20-17:30
6	Хэлэлцсэн асуудлаар санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс	17:30-17:40
6	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах, батлах	Хурлын нарийн бичгийн дарга: Б.Бат-Эрдэнэ	17:40-17:45
7	Хурлыг хаах	Хурлын дарга: Ц.Отгонбаяр	17:45-17:50

Үүний дараа асуулт, хариулт байна. Асуулт байвал тухай бүр нь тодруулаад явахыг хүсье.

Цаашлаад хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах, санал хураалтын дүнг танилцуулах, хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах, батлах, хурлыг хаах дарааллаар хурал үргэлжилнэ.

Хурлын дэгийг танилцуулж дуусав.

Өнөөдрийн хуралд Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Хурлын дарга Ц.Отгонбаяр танилцуулна.

Одоогийн танилцуулах үйл ажиллагааны тайлангаас та бүхэнд асууж тодруулах зүйл байвал нээлттэй шууд дунд нь асуугаад яваарай. Илүү ойлгомжтой байх болов уу?

За ингээд цааш нь үргэлжлүүлээд тайлангаа танилцуулъя.

Үйл ажиллагааны тайлан нь компанийн танилцуулга бүтэц, зохион байгуулалт салбар дэлгүүрүүдийн мэдээлэл, татан авалтын мэдээлэл, хувьцааны мэдээлэл, санхүүгийн үзүүлэлт, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулах гэх үндсэн агуулгын хүрээнд яригдана.

2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2026 оны зорилтуудын талаар Компанийн тухай хууль, “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцлээ. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2016 оны 07 сард тус компанийн хяналтын багцын хувьцааг худалдан авсан бөгөөд үүнээс хойших хугацаанд тус компанийн үйл ажиллагааг амжилттай үргэлжлүүлэн ажиллуулжээ.

Та бүхний мэдэж байгаачлан Ковидоос шалтгаалан сүүлийн 2020-2023 оны сүүл хүртэлх хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй. Үндсэн үйл ажиллагааны хувьд Татваргүй барааны дэлгүүрийн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааг явуулдаг.

Татваргүй барааны дэлгүүрийн 24 жилийн туршлагатай. 2 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Алтанбулаг болон Улаанбаатар төмөр зам салбар маань ажиллаж байна.

Салбар дэлгүүрүүдийн хувьд:

1-р салбар Төмөр замын дэлгүүрийн татваргүй барааны дэлгүүр нь вокзалын 2 дугаар давхарт байрладаг, гаалийн хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг. 2023 оны 6 сараас хойш үйл ажиллагаа богиносгосон цагаар явуулж эхэлсэн. Энэ оны 8 сараас эхлэн бүтэн цагаар ажиллах боломжтой гэсэн урьдчилсан таамаг байна.

2-р салбар Алтанбулаг шалган нэвтрүүлэх төвийн 1-р давхарт байрлан 46.7 м2 талбайтай үйл ажиллагаа явуулж байсан боловч Алтанбулаг хилийн боомт маань засварын ажил хийгдэхтэй холбоотой хилийн шалган нэвтрүүлэх байрыг бүр мөсөн буулгах болсон тул бид талбайг чөлөөлж өгсөн. Талбай чөлөөлөхтэй холбоотой бид өөрсдийн барааг түр гаалийн бүсэд контейнерт хадгалж байсан. 2022 оны 4 сараас эхлэн хойд хил нээх болсон, хөдөлгөөн хэвийн үргэлжлэх болсонтой холбоотойгоор бид Гаалийн байгууллагад хүсэлт өгсөөр 8 сараас эхлэн гаалийн бүсийн гадаа түр зөөврийн сууцанд үйл ажиллагаа явуулж байгаад өнгөрсөн одоос Алтанбулаг боомтын шинэ барилгад буцаад орж үйл ажиллагаагаа явуулж байна.

Өмнө дурдсанчлан “Таван Богд Холдингс” ХХК нь компанийн 70.94 хувийг, “БиДиСек УЦК” ХК нь сүүлд энэ оны 3 дугаар сараас хувьцаа эзэмшигч болж 6 хувийг эзэмшиж байна. Үлдсэн ойролцоогоор 23.06 хувь нь жижиг хувьцаа эзэмшигч нар байна.

Үйл ажиллагаатай холбоотой тайланг танилцуулж дууслаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: 2025 оны санхүүгийн тайлан, 2026 оны төсвийг болон Хөндлөнгийн аудитын дүгнэлт болон ТУЗ-ийн дүгнэлтийг компанийн Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга танилцуулна.

Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга:

Бүгдэд нь оройн мэнд хүргэе. “Жуулчин Дютти Фрий” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг танилцуулъя. 2024-2025 оныг хүснэгтээр харьцуулаад тайлангаа танилцуулъя.

2025 онд 1 тэрбум 442 саяын борлуулалтын орлоготой ажилласан байна. Нийт цэвэр ашиг нь бол 98 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: За баярлалаа. 2026 оны төлөвлөгөөг танилцуулъя.

Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга: 2026 оны зорилт дээр борлуулалтын төлөвлөгөөгөө 11% өсөлттэй төлөвлөн ажиллаж байгаа. Энэ жил 2 салбар хэвийн ажиллаж байгаа тул тодорхой хэмжээгээр борлуулалт өснө гэж харж байна. Борлуулалтын орлогыг 1.6 тэрбумын орлоготой ажиллана гэж төлөвлөж байгаа.

Үйл ажиллагааны зардлаа бол 778 саяд бариад нийт цэвэр ашгаа бол 168 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллана гэж төлөвлөсөн байгаа.

Хөндлөнгийн аудитын дүгнэлтийн хувьд бид 2025 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон “Шинэ Их Тэрбум” гэх аудитын компаниар аудит хийлгэсэн.

Өмнөх жил манай компанид аудит орж байсан газар юм.

2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гарсан аудитын тайланд ямар нэгэн зөрчил, зөвлөмж одоогийн байдлаар гараагүй хөндлөнгийн аудитын дүгнэлт гарсан байна.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаяр:

Санхүүтэй холбоотой өөр асуулт байгаа юу?

Хуралд оролцогчид байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Энэ жил хөндлөнгийн аудитаар Шинэ их тэрбум аудит компани орсон байгаа. Өмнөх жил бас манай дээр аудит орж байсан компани энэ жил дахин орсон.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: За хэлэлцэх дараагийн асуудлаа танилцуулаад явъя.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Энэ удаагийн хурлаар ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох шинээр томилох асуудлыг хэлэлцэхээр байна.

За үргэлжлүүлээд дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн товч намтар

ЦАГААЧИЙН БААТАРСАЙХАН

БОЛОВСРОЛ:

1984-1988 онд Политехникийн их сургууль Цахилгааны инженер, бакалавр, 1988-1989 онд Япон улс, Токиогийн гадаад хэл судлалын япон хэлний анги, 1989-1993 онд Япон улс, Токио хотын Цахилгаан холбоо, Электроникийн их сургууль, Электроникийн инженер, бакалавр

АЖЛЫН ТУРШЛАГА:

1993-1997 онд Япон-Монголын хамтарсан “Алтай” ХХК-нд Орлогч захирал,
1995 оноос Таван Богд Группийг үүсгэн байгуулсан, Таван Богд Группийн Ерөнхийлөгч, “Таван Богд Холдингс” ХХК-ийн Ерөнхий захирлаар одоог хүртэл ажиллаж байна.
1999-2000 онд “Жуулчин” ХХК-ийн Ерөнхий захирал,
2000-2001 онд Палас зочид буудал Гүйцэтгэх захирал,
2001-2003 онд “МИАТ” ХК-нд Санхүүгийн захирал,
2005 онд “Кемпински Хаан Палас” ХХК-нд Ерөнхий захирал,

2008-2024 онд “Говь” ХК-нд Гүйцэтгэх захирал,
 2009 оноос Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн,
 2016-2024 онд “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, даргаар тус тус ажиллаж байна.

ДАШДАВААГИЙН ХУЛАН

БОЛОВСРОЛ:

1985-1990 онд ОХУ улс, Москвагийн Санхүүгийн Дээд сургууль, Олон улсын эдийн засагч, бакалавр
 1992-1993 онд Монгол улс, Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн удирдлага, магистр

АЖЛЫН ТУРШЛАГА:

1990-1992 онд Монгол Улсын Сангийн яам, Гадаад харилцааны хэлтэс, Эдийн засагч
 1993-1997 онд Говь корпорац, Токио дахь салбар, Борлуулалтын менежер
 1997-2000 онд “Таван Богд Холдингс” ХХК, Тэргүүн дэд захирал
 2000-2002 онд Худалдаа хөгжлийн банк, дэд захирал
 2000-2002 онд Кредит Монгол зээлийн хоршооны гишүүн
 2003 оноос Таван Богд Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч
 2003 оноос Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн
 2008 оноос “Говь” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
 2009 оноос Люксембургийн Монгол Улс дахь өргөмжит консул
 2013-2023 онд Таван Богд Фүүдс ХХК, Таван Богд Фүүдс Пицца ХХК, Гүйцэтгэх захирал
 2016-2024 онд “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байна.

ЦАГААЧИЙН ОЮУНЦЭЦЭГ

БОЛОВСРОЛ:

1985-1990 онд 1987 онд ОХУ улс, НЭТДС-ийг УАС мэргэжлээр төгссөн, бакалавр

АЖЛЫН ТУРШЛАГА:

1987.07-1988.09 онд Бөөний Бараа Баазад Бүртгэлийн машины инженер
 1988.10-1993.02 онд Худалдааны Техникумд Компьютерын багш
 1993.03-1994.12 онд “Донот” ХХК-нд Нягтлан бодогч
 1995.06-2005.12 онд “Таван Богд” ХХК-ийн Гүйцэтгэх захирал,
 2005.01-2011.01 онд “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү хариуцсан захирал
 2011.01 оноос “Таван Богд Холдингс” ХХК-ийн Дотоод аудит хариуцсан захирлаар
 2016-2024 онд “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр тус тус ажиллаж байна.

ЦАГААЧИЙН ОТГОНСҮРЭН

БОЛОВСРОЛ:

1997-2002 онд Монгол улс, Улаанбаатар Дээд Сургууль, Эрх зүй, бакалавр

АЖЛЫН ТУРШЛАГА:

2002-2007 онд Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба, Мөрдөн байцаагч,
 2007-2013 онд БГД-ын Прокурорын газар, Прокурор
 2013-2019 онд Нийслэлийн Прокурорын газар, Прокурор
 2019-2022 онд ХУД-ын Прокурорын газар, Прокурор
 2022-2024 онд Тээврийн Прокурорын газар, Ахлах прокурор,

2024 оноос “Таван Богд Холдингс” ХХК-нд Хууль, эрхзүйн газрын захирлаар тус тус ажиллаж байна.

ЦАГААЧИЙН ОТГОНБАЯР

БОЛОВСРОЛ:

1998-2002 онд Хөдөө аж ахуйн их сургууль Газар зохион байгуулагч, бакалавр
2005-2009 онд Их Британи улс, UWIC , Аялал жуулчлалын менежмент, бакалавр,

АЖЛЫН ТУРШЛАГА:

2012-2015 онд Таван Богд Фүүдс” ХХК, Рестораны менежер, Төслийн ажилтан, Чанар,сургалтын албаны дарга
2016-2023 онд “Жуулчин” ХХК-ийн Гүйцэтгэх захирал,
2020-2023 онд “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч,
2023- оноос “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна.

ЧИМЭДРЭГЗЭН МӨНХТУЯА

БОЛОВСРОЛ:

2006-2010 онд Монгол улс, Монгол Улсын Их Сургууль, Эдийн засагч, Бакалавр
2013-2016 онд Монгол улс, Монгол Улсын Их Сургууль, Санхүүгийн менежмент, магистр

АЖЛЫН ТУРШЛАГА:

2010-2011 онд “Си Ти Эс Эн” ХХК-д, нярав
2012-2015 онд Монголиан морттейж фанд ББСБ, Нягтлан бодогч,
2015-2016 онд Монголиан морттейж фанд ББСБ, Зээлийн эдийн засагч,
2016-2018 онд Монголиан морттейж фанд ББСБ, Ахлах эдийн засагч,
2019-2020 онд “Таван Богд Фүүдс Пицца” ХХК, Санхүүгийн шинжээч,
2021-2022 онд “Таван Богд Фүүдс Пицца” ХХК, Санхүүгийн менежер,
2022-2024 онд “Таван Богд Фүүдс Пицца” ХХК, Санхүүгийн албаны дарга,
2024 оноос “Таван Богд Холдингс” ХХК-ийн санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга

БҮРЭНМЭНД ЛХАГВАДОРЖ

БОЛОВСРОЛ:

1983-1993 онд Монгол улс, 10 жилийн 5 дугаар Сургууль, Бүрэн дунд
1993-1997 онд Монгол улс, Техникийн Их Сургууль, Инженер

АЖЛЫН ТУРШЛАГА:

1999-2022 онд “БиДиСек ҮЦК” ХК-д, Тэргүүн дэд захирал
2022-оноос “БиДиСек ҮЦК” ХК-д, Гүйцэтгэх захирал

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн товч намтар

ДАШРЭНЦЭНГИЙН БАЙГАЛЬМАА

БОЛОВСРОЛ:

1987 онд ОХУ, Технологийн дээд сургуулийг, Технологич инженер
 1996 онд Удирдлагын институтыг Төрийн удирдлагын арга зүйч
 2006 онд Хүний нөөцийн институтыг, хүний нөөцийн менежер

АЖЛЫН ТУРШЛАГА:

1994-2006 онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газарт, Гадаад харилцаа, мониторинг хариуцсан түшмэл,
 2006-2010 онд “Монголорос Цветмент” ХХК-д Хүний нөөцийн менежер
 2010-2012 онд “Алтай Хүдэр” ХХК-нд Хүний нөөцийн уурхай хариуцсан мэргэжилтэн
 2013 оноос “Улаанбаатар БҮК” ХК-нд Хүний нөөц, сургалтын менежер, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
 2016-2024 онд “Жуулчин Дютти Фрий” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

ДЭМЧИГИЙН БОЛОРМАА**БОЛОВСРОЛ:**

1986 онд ЗХУ, Новосибирск хот, Цахилгаан Техникийн Дээд Сургууль, Системийн инженер
 1999 онд Шинжлэх ухаан технологийн их сургууль, Компьютерын шинжлэх ухааны магистр
 2016-2018 онд Удирдлагын Академийн Төрийн удирдлагын сургууль, Төрийн удирдлагын доктор

АЖЛЫН ТУРШЛАГА:

1987-1991 онд Сангийн яамны тооцоолон бодох төв, Программ зохиогч
 2004-2005 онд ЭМЯ-ы Эрүүл мэндийн шинэчлэлийг дэмжих техник туслалцааны төсөл, үндэсний зөвлөхөөр
 2004-2005 онд БСШУЯ-ы Боловсролын хөгжлийн хөтөлбөр-2, үндэсний зөвлөхөөр
 2007-2008 онд Сангийн яамны Засаглалын чадавхыг дээшлүүлэх төсөл, үндэсний зөвлөхөөр
 1991-2022 онд СЭЗИС, Мэдээллийн системийн тэнхим, Багш, тэнхимийн эрхлэгч
 2022 оноос одоог хүртэл СЭЗИС, ахисан түвшний сургууль, Ахисан түвшний профессор.

ДАШБАТЫН УЯНГА**БОЛОВСРОЛ:**

2010 онд Ерөнхий боловсролын 17-р сургууль, Бүрэн дунд
 2015 онд ОХУ, Эрхүү хотын улсын их сургууль, Хууль зүйн сургууль, Эрх зүйч, Бакалавр
 2022 оноос МУИС, Хууль зүйн сургууль, Магистрант

АЖЛЫН ТУРШЛАГА:

2015-2018 онд Хан-Уул дүүргийн Прокурорын газар, Мэргэжилтэн
 2018-2022 онд “Номин Холдинг” ХХК-д Гэрээт хуульч
 2022 оноос Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч
 2022 оноос Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч

За эдгээр ажил мэргэжлийн туршлагатай ердийн гишүүнд 7, хараат бус гишүүнд 3 хүн өрсөлдөх нь ээ.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Дарааллын хувьд танилцуулах, хэлэлцүүлэх асуудал байгаа. За дараагийн хэлэлцүүлэх асуудал буюу ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагаа санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулъя. “Жуулчин дюти фрий” ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан хийсэн ТУЗ-ийн дүгнэлт.

“Жуулчин Дюти Фрий” Хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг дүгнэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн дараах дүгнэлтийг гаргалаа.

Таван Богд Групп нь 2016 оны 07 сард тус компанийн хяналтын багцын хувьцааг худалдан авсан бөгөөд үүнээс хойших хугацаанд тус компанийн үйл ажиллагааг амжилттай хариуцан явуулсаар байна.

Улаанбаатар төмөр замын вокзал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Хилийн шалган нэвтрүүлэх цогцолборт салбар дэлгүүрүүдээр татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Ковид-19 цар тахлын үр нөлөөнөөс шалтгаалан манай үндсэн үйл ажиллагаа урт хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй, үүнээс үүдэн салбар дэлгүүрүүдээс Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг салбар 2022 оны 08 дугаар сараас, Төмөр зам салбар 2023 оны 06 дугаар сараас тус тус үйл ажиллагааг богиносгосон цагаар ажиллаж байгаа нь компани цаашид алдагдлаа нөхөж ажиллахад нөлөөлөл үзүүлэхээр байна.

2025 онд компанийн 2 /Алтанбулаг, Төмөр зам/ салбар үйл ажиллагаа гаалийн баталсан хуваарийн дагуу эрхэлсэн бөгөөд санхүүгийн жилийн эцсийн тайлан бидний зорилтод түвшинд хүрээгүй байна. Өөрөөр хэлбэл борлуулалтын гүйцэтгэл 2025 онд 79.8%, ашгийн биелэлт 77.8 %-тай байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны цэвэр ашгийн гүйцэтгэл 61%-тай байна.

Тус компани 2025 оны төлөвлөгөөгөөр 1.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байсан үүнээс 1.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь төлөвлөгөөгөө 79.8%-тай биелүүлсэн байна. Мөн хүүгийн орлогын зөрүүгээс 158.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Компанийн хэмжээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2024 оны 05 сараас эхлэн чөлөөт бүс нээгдсэнтэй холбоотой борлуулалтын орлого буурсан боловч компани нөөц бололцоогоо дайчлан ажилласан гэж дүгнэж байна.

Цаашид татваргүй барааны дэлхийн стандарт жишигт нийцсэн дэлгүүрийн үйлчилгээг нэвтрүүлэн олон улсын болон дотоодын зорчигчид, жуулчид болон татваргүй барааны дэлгүүрээр үйлчлүүлэх эрх бүхий этгээдэд үйлчилгээг өргөн хүрээнд үзүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөсөн байгааг тэмдэглэж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцсэн асуудлууд дууслаа, хэлэлцсэн асуудлын хүрээнд тооллогын комиссоос 4 асуудлаар санал хураалт явуулна.

Саналын хуудас болон санал хураалттай холбоотой асууж тодруулах зүйл байвал нээлттэй шүү.

Эхний 3 санал хураалт дээр ердийн санал хураалт явагдана.

Харин ТУЗ-ийн гишүүдийн томилох санал хураалт дээр бид КТХ болон СЗХ-ны баталсан кумулятив аргаар санал хураалтыг явуулж тоолно. Та бүхэнд дэлгэрэнгүй хэрхэн саналаа өгөх талаар тайлбарлаж өгье.

Кумулятив санал өгөх заавар:

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй болохыг анхаарна уу.

Санал хураалт явагдаж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тооллогын комиссоос 4 саналын дүнгээ нэгтгэн та бүхэнд танилцуулахад бэлэн болсон байна.

Тооллогын комиссын дарга Э.Оюунпүрэв: Нийт өнөөдрийн хуралд 3 хувьцаа эзэмшигч оролцсоноос 100% хувь зөвшөөрсөн, санал өгснөөр компанийн 2026 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах батлахаар шийдвэрлэсэн байна.

Саналын 2-р хуудас буюу ТУЗ-ийн 2025 санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг саналын хуудсыг 100% зөвшөөрсөн санал өгснөөр батлахаар шийдвэрлэсэн байна.

Саналын 3-р хуудас буюу “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохыг батлах саналын хуудсыг 100% зөвшөөрсөн санал өгснөөр батлахаар шийдвэрлэсэн байна.

Саналын 4-р хуудас буюу ТУЗ-ийн гишүүдийг томилох дараах санал өгснөөр батлахаар шийдвэрлэсэн байна. Хүн тус бүрээр саналын танилцуулъя.

Ердийн гишүүдийн санал хураалтын дүн

Ердийн гишүүдээр

Ц.Баатарсайхан 46,368 санал, Д.Хулан 46,473 санал, Ц.Оюунцэцэг 46,368 санал, Ц.Отгонсүрэн 46,368 санал, Ц.Отгонбаяр 50,370 санал, Ч.Мөнхтуяа 46,368 санал, Б.Лхагвадорж 35,421 санал тус тус авсан байна.

Хараат бус гишүүдээр

Д.Байгальмаа 46,368 санал, Д.Болормаа 48,473 санал, Д.Уянга 46,368 санал

Тус тус саналыг авсан байна. Эдгээр гишүүдээс санал авч ТУЗ-ийн гишүүнээр дараах гишүүд сонгогдсон байна.

Ердийн гишүүдээр

1. Ц.Баатарсайхан 46,368 санал
2. Д.Хулан 46,473 санал
3. Ц.Оюунцэцэг 46,368 санал
4. Ц.Отгонсүрэн 46,368 санал
5. Ц.Отгонбаяр 50,370 санал
6. Ч.Мөнхтуяа 46,368 санал

Хараат бус гишүүдээр

7. Д.Байгальмаа 46,368 санал
8. Д.Болормаа 48,473 санал
9. Д.Уянга 46,368 санал

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ:

1. ТУЗ-ийн зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай
2. 2026 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах тухай
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон Хараат бус гишүүдийг шинээр сонгох тухай

Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд оруулсан 4 асуудлыг хувьцаа эзэмшигч нар дэмжигдсэн учраас тогтоолын төслийг батлахаар шийдвэрлэсэн тул тогтоолын төслийг танилцуулан баталлаа.

Ингээд өнөөдрийн хурал өндөрлөж байна хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн Ц.Отгонбаяр захирлыг урьж байна.

Хурлын дарга, Гүйцэтгэх захирал Ц.Отгонбаяр: “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Та бүхний саналыг хурлын протоколд тусган ТУЗ-ийн гишүүдэд танилцуулах болно. Шаардлагатай бол бидний үйл ажиллагааг дэмжвэл бид тун таатайгаар хүлээн авах болно. Энэхүү хуралд ирж, үзэл бодол, саналаа хуваалцсан явдалд дахин талархал илэрхийлье. Хувьцаа эзэмшигчид өөрсдийн үзэл бодол, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь компанийн үйл ажиллагааг илүү ил тод, бодитой болгож хамтын амжилтанд хүргэдэгт би итгэдэг. Миний зүгээс илүү хичээн ажиллах болно. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурлын дарга:



Ц.Отгонбаяр

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Б.Бат-Эрдэнэ

2026 оны 04 сарын 30-ны өдрийн 17 цаг 15 минутад дуусав.